

ГЕРМАНЫ УЛС ТӨР, НИЙГМИЙН АМЬДРАЛ

Германы төрийн байгууллын хөгжил дэх улс төрийн нөхцөл байдлын нөлөө

*МУИС-ын Хууль Зүйн Сургуулийн
докторант Сарлагтай О. Машбат*

Герман улсын үндсэн хуулийн тогтолцооны улс төрийн орчин, түүний нөлөөлөл Үндсэн хуулийн эрх зүйд хэрхэн тусгалаа олсон тухай асуудлыг энэ өгүүлэлдээ шүүмжлэн үзэхийг эрмэлзэн зорив.

Герман улс дундад зууны турш тархай бутархай ханлиг ванлигт хуваагдан оршсоор 19 дүгээр зууныг хүргэсэн юм. Наполеоны удирдлага дор хийсэн Францын байлдан дагуулал үндэсний нийтлэг мэдрэмжийг* цогц болгон төлөвшүүлж өгсөн¹ гэдэг. Ватерлоогийн тулалдаанд ялалт байгуулсан Пруссын цэргийн амжилт ч үүнд чухал хувь нэмрээ оруулсан билээ. Германы нийгэмд гарч ирсэн газрын эздийн “юнкер” хэмээх давхарга худалдаа наймааны ашиг орлогын үүднээс герман угсаатан ванлиг ханлиг эдийн засаг улс төрийн хувьд нэгдмэл байх хэрэгтэй гэсэн санааг нийгэмд идэвхтэй түгээж байлаа.

1834 онд чухамхүү юнкерүүдийн шахалтаар Прусс тэргүүтэй улсууд гааль тарифийн нэгдсэн систем байгуулж, харилцан татваргүй буюу бага татвартайгаар ванлиг хооронд худалдаа хийх эрхийг нээсэн юм. Энэ гэрээ хил дамнасан эдийн засаг бизнесийн тун таатай орчин бүрдүүлж, герман угсаат тэдгээр ванлиг эдийн засгийн нэгдсэн сүлжээнд эрхгүй уягдан холбогдох эхийг тавьсан байна. Нэгдсэн эдийн засгийн сүлжээ бэхжих тусам тэнд герман угсаатны нэгдсэн улсыг байгуулах “үндэсний үзэл” хүчтэй дэлгэрч, нийгэм даяар түгсэн

¹ Alfred Katz “Staatsrecht” Heidelberg 1991, S.36

байна. Цоллферайн** хэмээн алдаршсан энэ гаалийн нэгдэлд эдийн засгийн ашиг сонирхолын үүднээс герман угсааны улс үндэстэн нэгдэн орсоор хожим энэ нь Умард Германы Конфедерац болон өргөжсөн билээ.²

1862 онд Велгильм ван хязгаар нутгийн юнкер Отто фон Бисмаркийг канцлер буюу тэргүүн сайдаар томилсон нь хожим Германы түүхэнд эргэлтийн чанартай үйл явдал болсон юм. Бисмаркийн улс төрийн зорилго нь Пруссийн манлайлал дор герман угсаатны нэгдсэн төр улсыг байгуулах явдал байлаа. Энэ зорилгод ямар ч үнээр хамаагүй хүрэх ёстой, тийм ч учраас Прусс дэх Бисмаркийн засаглал эхний жилүүдэд цэргийн дэглэм тогтоон, парламентыг тарааснаар эхэлсэн билээ. Учир нь Германы нэгдлийн төлөө Пруссийн армийг бэхжүүлэх төсвийг парламент эсэргүүцэж байв. Чухам иймээс түүнийг “германы ардчилсан үзэлтнүүд” гэгдэх либераль, социалистууд “төмөр канцлер” хэмээн хочилж байлаа.

Бисмаркийн удирдлага дор Герман улс түүхнээ “нэгдлийн дайн” хэмээн алдаршсан гурван дайн явуулсан юм. Дани - Пруссийн дайн, Австри - Пруссийн дайн, Франц - Пруссийн дайн хэмээх алдарт дайныхаа дараа Бисмарк герман угсаат ванлигуудын дундахь Австрийн нөлөөг унагаж Пруссээр төв хийн даяар Германыг нэгтгэжээ.

Франц Пруссийн дайнаар Пруссийн цэрэг Парист байрласан нь Наполеон III хаан ширээг түлхэн унагаж, Хоёрдугаар Бүгд Найрамдах Улсыг байгуулах аятай нөхцлийг францчуудад олгосон юм. Гэвч энэ гол бус.

* Anatole Mazour, John M. Peoples and Theodore K. Rabb (ed) “People and Nations; A World History” Harcourt Brace Jovanovich, Publisher 1988, p. 532

1871 онд Парисаас холгүй орших эзэн хааны тансаг хотхон Версалийн Толин танхимд Германы Эзэнт Гүрэнг зарлан тунхаглаж, Пруссын ван Велгильм I-ийг тус гүрний хаан ширээнд залсан нь энэ явдлын гол үр дүн байлаа.

Кайзерын Эзэнт Улс

Германыг нэгтгэсэн үеэс эхлэн Бисмаркийн бодлого зорилт Германы дотоод эв нэгдлийг хангахад чиглэж эхэлсэн билээ. Пруссын дайнч милитарист гадаад бодлого эрс өөрчлөгдөж, дотоод асуудалд илүүтэй анхаарал тавьж, нийгмийн тогтвортой байдлыг хадгалахыг эрмэлзэх болов. Дөнгөж байгуулагдсан Эзэнт гүрний өмнө багцаалж бодоход дараахь үндсэн зорилт тулгарч байлаа. Тухайлбал,

- харьяанд дөнгөж ороод байгаа жижиг ванлиг ханлигийн улс төрийн амбицийг тэнцэржүүлэн тогтоох. Эс тэгвээс, эзэнт гүрэн дөнгөж нэгтгэсэн олон ванлигт эргээд задрах аюул бодитой нүүрлэж байлаа.

- дайны хөлд зүдэж ядарсан олон нийтийн дургүйцлийг намжаах. Пруссын милитарист бодлого, төсвийг эсэргүүцсэн хүчин бүр анхнаасаа байсаар байсан бөгөөд чухам тэдний эсэргүүцлийг дарангуйлахын тулд парламентыг тарааж байсан билээ. Тэдгээр сөрөг хүчин социалист, коммунист үзлийг онолын хувьд цэгцлэн Бисмаркийн бодлогын өөдөөс эсэргүүцэх гол далбаагаа болгож байв. Нэгдлийн дайнд туйлдсан ард түмний аж байдал, нийгмийн сэтгэлзүй нь тэдэнд байр сууриа бэхжүүлэх таатай боломж олгосон юм.

- Герман угсааны ванлиг зуурын задралд эрт үедээ протестант, католик шашны хагарал чухал үүрэг гүйцэтгэн, гучин жилийн дайны эмгэнэлд хүргэсэн бөгөөд шашны энэ ялгаа хадгалагдсаар байлаа. Салан тусгаарлахыг санаархсан зарим ванлиг, Прусст эрхээ алдсан Австри зэрэг улс ч шашны хүчин зүйлийг залуу холбооны эсрэг гол зэвсгээ болгон ашиглаж байв.³

³ Anatole Mazour, John M. Peoples and Theodore K. Rabb (ed) "People and Nations; A World History" Harcourt Brace Jovanovich, Publisher 1988, p 537

Эдгээр асуудлыг шийдвэрлэхийн тулд Бисмарк олон зүйл оновчтой бодлого боловсруулан хэрэгжүүлсэн билээ. Шашны нөлөөнөөс улс орныг ангижруулахын тулд “Соёлын тэмцэл”*** өрнүүлж, нийгэм дэхь шашны нөлөө, шашны урсгалын зөрчлийг нийгмийн анхаарлын гадна гаргахыг зорьж байв. Бисмаркийн засаглалын жилүүдэд хүүхдийн ясли, цэцэрлэг гэгч зүйлийг анх санаачилж, хотын дотор автобус хэмээх нийтийн унаа зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэх болсон нь нийгэмд төрсөн бухимдлыг багасгаж ажилчин ангийн нийгмийн хамгааллыг баталгаажуулах замаар нийгмийн тогтвортой байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа байлаа.

Чингэж эдгээр асуудлыг улс төрийн бодлогын хүрээнд шийдвэрлэснээс гадна Үндсэн хуулийн тогтолцоондоо энэ асуудлыг чухалчлан үзэж зохицуулсан хандлага хүчтэй ажиглагддаг.

Юун түрүүнд төрийн байгууллын тал дээр гишүүн ванлигуудын ашиг сонирхлыг дээдлэн үзэх хандлага илэрхий байдаг.

Эзэнт гүрний төрийн байгууллын хэлбэрийн хувьд Эзэн хаант засаг бөгөөд асар төвлөрсөн шинжтэй байлаа. Засаглал хуваах онолын ерөнхий суурь бий боловч яг засаглал хуваах онолыг эш болгон байгуулсан гэхэд түвэгтэй. Бундесрат нь төрийн цорын ганц дээд байгууллага бөгөөд өөрийн шинжээрээ хууль тогтоох, бас гүйцэтгэн захирамжлах эрх мэдлийн зарим хэсгийг эдэлж байжээ.⁴

Ерөнхийдөө хууль тогтоох чиг үүрэг бүхий Бундесрат⁵, түүний дор зөвлөх эрх бүхий Рейхстаг хэмээх байгууллага байх агаад Эзэн хаан, түүнээс томилогдсон Рейхсканцлер

⁴ Alfred Katz “Staatsrecht” Heidelberg 1991, S.36

⁵ Кайзерын Үндсэн хууль 5, 7 дугаар зүйл

гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлнэ. Одоо эдгээр байгууллагын бүтэц, чиг үүргийн талаар авч үзье.

Бундесрат хэмээх холбооны ванлигуудын Ландтаг хэмээх хурлаас сонгогдсон төлөөлөгчдөөс бүрдэнэ. Өөрөөр хэлбэл, холбооны мужуудын ашиг сонирхолыг илэрхийлсэн байгууллага юм. Ерөнхийдөө эзэн хааны эрх мэдлийг хязгаарлах, хянахад чиглэсэн улс төрийн уламжлалт механизмын шинжтэй. Анх удаа 13 дугаар зуунд Англид Парламент үүсэхдээ л эзэн вангийн эрхийг хязгаарлах зорилгоор үүссэн лорд ноёдын нэгдэл байсан⁶ бөгөөд Францад ч мөн л зорилгоор Ерөнхий штат үүссэн. Германы тусдаа ванлигуудад Гамбург зэрэг бүгд найрамдах засагтай хот улсыг эс тооцвол бас л вангийн эрхийг хязгаарлах ноёдын чуулган хэлбэрээр Ландтаг*** үүссэн юм. Бундесратын эрх мэдлийн ерөнхий хэм хэмжээ яг энэ механизмын шинжийг агуулна.

Бундесратын Эзэн хаантай сөргөлцсөн байдал нь хууль тогтоох байгууллагад төвлөрсөн ноёдын эрх ашиг болоод гүйцэтгэх засаглалаар төлөөлсөн Эзэн хааны эрх ашиг төдийгүй, холбооны засгийн газар болон муж улсын хоорондын зөрчлийг илэрхийлж байлаа. Бундесрат буюу Холбооны зөвлөлд төлөөлөгч сонгогдсон хэрээр муж улс орон нутгийнхаа бие даасан байдлыг хангах, ашиг сонирхолоо тусгах бололцоотой байлаа. Тэдгээр ашиг сонирхол нь тухайлан Бундесратын хүрээнд л хэлэлцэгдэн, зөвшилцөлд хүрэх ёстой. Эс хүрвэл Пруссийн ашиг сонирхлыг төлөөлөгч Холбооны засгийн газрын тэргүүний дур зоргоор явахад хүрнэ. Иймээс Бундесрат заавал нэгдсэн саналтай байх ёстой бөгөөд баталсан хууль нь холбооны олон мужийн ашиг сонирхлын тэнцвэр болдог байв. Үүгээрээ АНУ дахь Сенатын үүрэгтэй төстэй байлаа.

⁶ Л.Өлзийсайхан "Парламент" Улаанбаатар 2001, хуудас 22-23

Харин Рейхстаг буюу Эзэнт гүрний хурал нь Бундестагтай харьцуулахад зөвлөх эрхтэй байгууллага байсан юм. Рейхстаг хүн амыг тэгш хуваасан тойргоос шууд сонгодог гишүүдээс бүрдэх бөгөөд улс төрийн намын ашиг сонирхол энэ хүрээнд илрэх ёстой юм. Тэр үеийн консерватив удирдагчид олон түмнийг үймүүлж байдаг улс төрийн нам, байгууллагад итгэлгүй ханддаг байсан бөгөөд тиймээс төрийн хэрэгт оролцох явдлыг аль болох багасгах арга механизм эрэлхийлж байсан нь Рейхстаг байлаа. Дайны хөлд туйлдсан ард олныг төв засгийн газрын эсрэг турхирч байгаа улс төрийн намуудын довтолгооныг сааруулахын тулд барьсан энэ институт төрийн байгууллын нийт системд бараг үүрэггүй шахуу байлаа. Удалгүй “чалчаа тэнхим” хэмээн хочлогдох болсон нь⁷ улс төрийн ийм учир шалтгаантай юм. Рейхстаг хууль, төсөв зэрэг баримт бичигт гагцхүү зөвлөмж өгөх эрхтэй байгууллага юм. Түүнийг хэрэгсэх эсэх нь Эзэн хаан, Бундесратын дур. Үүгээрээ хүн амын төлөөллийг илэрхийлэн, хууль төсөв батлахад голлох рольтой оролцдог АНУ-ын төлөөлөгчдийн тэнхимээс илт өмнөө билээ.

Рейхсканцлер ерөнхий агуулгаараа гүйцэтгэн захирамжлах эрх мэдлийг хэрэгжүүлэх боловч түүний дор ерөнхий сайдын тэнхим ч юм уу, сайд нарын зөвлөл ч юм уу ямар нэг институт байна гэсэн заалт үгүй. Тиймээс гүйцэтгэн захирамжлах эрх мэдлийг ганц хүний гарт атгуулсан хэмээн шууд хэлж болох бөгөөд тэр нь Пруссийн Эзэн хаанаас томилогдоно⁸. Иймээс Канцлер ажил үүргээ ихэвчлэн Пруссийн гүйцэтгэн захирамжлах тэнхимд тулгуурлан явуулах жишиг хожим тогтсон ба мөнхүү Үндсэн хуульд заасан ёсоор Ландтаг, ванлиг, муж улсын захиргаад нь өөр өөрийн ёсоор томилогдон огцрох авч шууд Канцлерийн захиргаанд ажиллах ёстой байлаа⁹.

⁷ *Vaughn F. Bishop, J William Meszaros. "Comparing Nations; The developed and the developing world", Toronto 1980, p 52*

⁸ *Кайзерийн Үндсэн хууль 15 дугаар зүйл.*

⁹ *Alfred Katz "Staatsrecht" Heidelberg 1991, S.36*

Энэ бүхнээс дараахь дүгнэлтийг хийж болох юм.

- 1871 оны Германы Эзэнт Гүрний Үндсэн Хуульд дэвшүүлэн тавьсан гол зорилт нь юун түрүүнд, герман үндэстний нэгдлийг хангахын тулд муж улсын ашиг сонирхлыг илэрхийлсэн бүтцэд хууль тогтоох эрх мэдэл, хүндийн төвийг өгчээ. Бундесрат нь тулгар нэгдсэн олон мужийн улс төрийн сонирхлыг тэнцвэржүүлэх, тэдний ашиг сонирхлыг хуульд тусган хангах замаар нэгдлийг бэхжүүлэхэд чухал үүрэгтэй механизм болсон байна. Бундесрат нь:

- Хууль тогтоох байгууллагын хувьд гүйцэтгэх эрх мэдэл буюу Эзэн хааны засгийг хянах үүрэгтэй байлаа. Энэ нь дээр өгүүлснээр парламентын уламжлалт үүрэг мөн.
- Олон муж улсаас сонгогдсон төлөөллийн байгууллагын хувьд муж улсын сонирхол, тэдгээрийн зөрчлийг шийдвэрлэх механизм байв. Жижиг, том улсын хоорондын зөрчил, протестант умар, католик өмнө хоёрын үл ойлголцлыг холбооны хүрээнд шийдэх институт байлаа. Энэ нь улс төрийн хоёр үр дагаварт хүргэсэн юм.

◀ Бундесрат нь муж улсын ашиг сонирхлын зөрчлийг улс төрийн аргаар зөвшилцөх, буулт хийх, шийдвэрлэх механизм болсон.

◀ Уг зөрчлийг Холбооны засгийн газрын бэлэгдэл Эзэн Хаанд хүргэлгүй шийдвэрлэснээр Холбооны засгийн газрын нэр хүндийг хамгаалж байлаа.

Иймээс 1871 оны Үндсэн хуулиар тодорхойлсон Бундесрат нь герман үндэстний төлөвшил, нэгдэл нягтралд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн институт юм.

- Мөн үед нэгдлийн дайны улмаас хүн амын дургүйцлийг багасгах, тэдгээрийн эрх ашгийг илэрхийлсэн улс төрийн намын янз бүрийн сонирхол, хийрхэлийг төрийн байгууллын хүрээнд тогтоон барих явдал чухлаар тавигдаж байсан. Энэ үүргийг Рейхстаг гүйцэтгэсэн байна. Рейхстаг нь хүн амын төлөөллийг илэрхийлсэн зөвлөх эрх бүхий байгууллага юм. Рейхстагийн үйл ажиллагааны улс төрийн үр дагаврыг тоймловол:
 - Улс төрийн намуудаар дамжсан хүн амын сонирхлыг төрийн түвшинд төлөөлснөөр тэдгээрийн дургүйцэл, бухимдлыг намжаах институц болжээ. Эдгээр ашиг сонирхолд, салан тусгаарлах сонирхол ч багтаж байгааг тэмдэглэх хэрэгтэй.
 - Гэвч тэдгээр ашиг сонирхлыг зөвлөх эрхтэй институцэд хашснаараа улс төрийн бодлогод нөлөөлөх явдлыг нь хязгаарлаж өгсөн байна. Энэ нь германы нийгэм ардчилах явцыг сааруулжээ. Магадгүй, хүчээр нэгтгэсэн эхний үед тийнхүү хүч хэрэглэхийг эсэргүүцсэн либераль, социалист сонирхлыг улс төрийн бодлогын гадна шүүн тунгааж үлдээх шаардлага байсан байж болох юм.
- Бүхэлд нь дүгнэвэл Германы Эзэнт Гүрний засаглал нь хэт төвлөрлийг дэмжсэн хандлагатай байлаа. Засаглалын бүтцийг харвал, улс төрийн бодлогод муж улсын ашиг сонирхлыг тусгах, тэнцвэржүүлэхийг чухалчлан Бундесрат, Эзэн хаан хоёрын дунд эрх мэдэл хуваарилж, өөрөөр хэлбэл хүндийн төвийг байрлуулжээ. Харин улс төрийн нам зэрэг нийгмийн бусад хүчний, харьцангуй ач холбогдол багатай, магадгүй аюултай гэж үзсэн эрх ашиг төрийн бодлогод тусахыг хязгаарлаж, шүүн тунгаах зорилгоор Рейхстагийн эрхийг хязгаарлаж зөвлөх эрхтэй үлдээжээ. Иймээс энэ үеийн улс төрийн шийдвэр нь муж улсын ашиг сонирхлын илэрхийлэл болон гарч байснаас бус нийгмийн анги давхарга, бүлгийн ашиг сонирхлын илэрхийлэл болж чаддаггүй байжээ.

Ваймарын Иргэн Улс * * * *

Дэлхийн нэгдүгээр дайн хэдийгээр Герман тэргүүтэй холбоотнуудын ялагдлаар төгссөн боловч Герман угсаатан нэгэн үндэстэн болон төлөвшсөнийг батлан харуулжээ. Иймээс муж улсын ашиг сонирхлыг байнга харгалзан үзэх нь Бисмаркийн дор дөнгөж нэгдээд байсан үеийг бодвол ач холбогдол бага болсон байв.

Дайны дараа Германы дотоод улс төрийн байдал самуунтай байсан нь ихэвчлэн нийгмийн бүлэг, улс төрийн хүчний тэмцлээс шалтгаалж байлаа. Нөгөө талаас ялсан гүрний улс төрийн шахаан дор Германы гадаад байдал бас төдийлөн таагүй байсан юм. Энэхүү улс төрийн гадаад дотоод байдал нь Ваймарын Иргэн улсын Үндсэн хуулийг батлахад гол түлхэц болсон гэж үздэг.

Орос оронд өрнөсөн Октябрийн хувьсгал, залуу Зөвлөлт засгийн хувьсгалыг эскпортлох гадаад бодлогын үр дүнд Берлин хот ажилчдын мэдэлд орчихоод байсан энэ үед Ваймар хэмээх жижиг хотод уг үндсэн хуулийг батлан гаргасан нь хожмоо Ваймарын Үндсэн хууль хэмээн түүхнээ нэршин, уг үндсэн хуулиар тунхагласан улсыг нь Ваймарын Иргэн улс хэмээн нэрлэх болсон билээ.

Ваймарын Үндсэн хууль батлагдсан цагаасаа л Америк загварыг барьсан хэмээн шүүмжлэгдэн¹⁰, Версалийн гэрээгээр тулгагдсан зүйл болохоос Германы ард түмний чин хүслийг тусгаж чадаагүй хэмээн ад үзэгдэж байв. Ваймарын Үндсэн хуулийн улс төрийн зорилго нь Эзэн хаант байгууллыг Иргэн улсын байгууллаар солих, төвлөрлийг сааруулан ардчилалыг хөгжүүлэхэд чиглэж байжээ. Улс төрийн энэ зорилго ч тус үндсэн хуулиар баталгаажсан төрийн байгууллын бүтцэд тусгалаа олсон байдаг.

¹⁰ *Anatole Mazour, John M. Peoples and Theodore K. Rabb (ed) "People and Nations; A World History" Harcourt Brace Jovanovich, Publisher 1988, p 678*

Ваймарын Иргэн улсын төрийн байгуулал нь ерөнхийлөгчийн иргэн улсын байгууллыг үндэс болгосон байна. Гэхдээ төрийн тэргүүнээс Канцлерийг томилдог зэрэг хуучин Эзэнт гүрний зарим систем хадгалагдан үлджээ.

Төрийн байгуулалд ард түмнээс сонгогддог Гүрний хурал буюу Рейхстагийн үүрэг ач холбогдол эрс өсч хууль тогтоох гол байгууллага болон тодров. Бундесратын чиг үүргийг уламжлан авсан Гүрний зөвлөл буюу Рейхсратын үүрэг багасч зөвлөх үүрэгтэй институт болсон юм.

Рейхстаг нь ард түмнээс шууд сонгосон гишүүдээс бүрэлдсэн хууль тогтоох байгууллага юм. Дөрвөн жилд нэг удаа ардчилсан шууд сонгуулийн үр дүнд Рейхстаг сонгогдоно. Рейхстагийн сонгууль порпорциональ системээр явагдах бөгөөд нийгэм дэхь ул төрийн ашиг сонирхлыг тэнцвэржүүлэх нь парламентын үүрэг болсон байна.

Рейхс- ерөнхийлөгч буюу Эзэнт гүрний Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн бөгөөд ард түмнээс шууд сонгогдоно. Долоон жилийн хугацаатай үүрэг гүйцэтгэнэ.¹¹ Тэрээр ард түмний эв нэгдлийг илэрхийлнэ.

Гүйцэтгэх эрх мэдлийг Рейхс-ерөнхийлөгчөөс томилогдсон Рейхсканцлер гүйцэтгэж, Рейхсканцлерын санал болгосноор мөн Ерөнхийлөгчөөс томилогдох Рейхсминистер буюу Эзэнт гүрний сайд нараас гүйцэтгэх тэнхим бүрдэнэ.

Улс төрийн бодлогын ерөнхий шугамыг Рейхсканцлер тодорхойлох бөгөөд засгийн газрын гишүүд дор бүрээ чиглэл хариуцан, бодлогын шугамын хүрээнд үйл ажиллагаагаа эрхэлнэ.¹² Бодлогын хэрэгжилтийг Рейхстаг хянана.

¹¹ Ваймарын Үндсэн хууль 43 дугаар зүйл

¹² Ваймарын Үндсэн хууль 56 дугаар зүйл

Рейхсратын үндсэн үүрэг өөрчлөгдөж, холбооны мужуудын эрх ашиг гагцхүү хуульд зөвлөмж өгөх хэлбэрээр л илэрдэг болжээ. Аливаа хуулийн төсөл Засгийн газар Рейхсрат хоёрын санал нийлэх ёстой бөгөөд хэрэв санал хоёронтаа үл нийлвэл хуулийн төсөл, түүнд буй зөрөөтэй саналууд хамтдаа Рейхстагт орж шийдвэрлэгдэнэ.¹³ Рейхсрат хууль санаачлах эрхгүй бөгөөд хэрэв санаачилбал түүнийгээ Рейхастагийн гишүүд буюу Рейхын засгийн газрын дэмжлэгтэйгээр хэлэлцүүлэгт оруулж болно. Гэхдээ Рейхсрат Рейхстагийн баталсан хуульд хоёр долоо хоногийн дотор хориг тавих эрхтэй¹⁴ агаад энэ тохиолдолд Рейхс-ерөнхийлөгчийн байр суурь нэмэгдэнэ.

Рейхсратын хуралдааныг Рейхсканцлер буюу Рейхийн засгийн газрын гишүүн даргална.¹⁵

Энэ бүхнээс харахад дараахь хэдэн зүйл дүгнэлт хийж болох юм.

- 1871 оноос хойшхи Германы нэгдсэн төрт ёс нэгэнт төлөвшиж, Герман үндэстэн нэгэнт бүрэлдэн тогтоод Холбооны улсын байгуулал, легитим шинжээ олсон байв. Иймээс тус улсын төрийн байгууллын гол зорилт нь Холбооны улсыг бэхжүүлэхэд бус харин тус улсад ардчилсан системийг төлөвшүүлэхэд голлон анхаарах болсон юм. Энэ нь төрийн байгуулалд дараахь зүйлээр тодорч гарч иржээ. Үүнд:
 - Холбооны зөвлөлийн гүйцэтгэх үүрэг багасч,
 - Холбооны хурлын гүйцэтгэх үүрэг өссөн явдал юм.

¹³ Ваймарын Үндсэн хууль 69 дүгээр зүйл

¹⁴ Ваймарын Үндсэн хууль 74 дүгээр зүйл

¹⁵ Ваймарын Үндсэн хууль 65 дугаар зүйл

Үүнээс улбаалан

- Бундесратын чиг үүргийг өвлөсөн Рейхсратын гүйцэтгэх үүрэг эрс буурч, Рейхсрат шууд Гүйцэтгэх эрх мэдлийн хүрээнд зөвлөлдөх байгууллага болон хувирчээ. Хууль тогтоох эрх мэдлийн хүрээнд өвлөж авсан зүйл огт үгүй шахуу бөгөөд гагцхүү хуулийн төсөлд зөвшилцөх төдийгөөр хязгаарлагдах болсон байна.
 - Рейхстагийн гүйцэтгэх үүрэг өсөн нэмэгдэж, хууль тогтоох байгууллага болон тодров.
- Ваймарын Иргэн улсын төрийн байгууллыг үзвэл ганц тэнхимтэй парламентын бүтэцтэй байсныг цохон тэмдэглэх хэрэгтэй. Рейхстаг бол хууль тогтоох цорын ганц байгууллага билээ. Харин Рейхрат нь Рейхийн засгийн газрын дэргэдэх зөвлөх институц болохоос парламентын нэг тэнхим биш юм. Учир нь:
 - Үндсэн хуульд Рейхсратын тухай хэсэг нь Рейхстаг, Рейхс-ерөнхийлөгч ба Рейхийн Засгийн газар гэсэн хэсгийн дараа орж байгаа нь норматив үүднээс үзвэл, хууль тогтоох байгууллагын хэсэг хэмээн үзэхэд учир дутагдалтай.
 - Рейхсратыг даргалах эрх Рейхсканцлер, Рейхс сайд, өөрөөр хэлбэл гүйцэтгэх тэнхимийн гишүүдэд хадгалагдана.
 - Рейхсратын үүрэг бол хэрэв хууль шийдвэрт хориг тавих эрхийг эс тооцвол, хууль санал өгөх, эсрэг саналаа хавсарган Рейхстагт оруулах төдийгөөр хязгаарлагдаж байгаа юм.
 - Өөрөөр хэлбэл, өөрийн санаачлагаар биш гэхэд шууд орлоотойгоор шийдвэр гаргах бүрэн эрх байсангүй.

Иймээс Рейхсрат бол парламентын нэг танхим бус, харин төрийн байгуулал дахь зөвлөх эрх бүхий субъект юм.

Ваймарын Иргэн улс Гитлер тэргүүтэй нацистууд засгийн эрхэнд гарснаар төгсгөл болжээ. Үүнд нийгмийн олон хүчин зүйл үйлчилсэн боловч Үндсэн хуулиар тогтоосон механизм нь дарангуйлагч төрөх бололцоо гаргаж, улс төрийн арга хэрэгслийн үр дүнд бодит байдал болон хувирчээ.

Дэлхийн дайн өдөөсөн хэмээн яллагдсан Германы ард түмний сэтгэл санааны уналт, ерөнхийлөгч Гинденбургийн сул авир, гадаад их гүрнүүдийн хайхрамжгүй байдал нь эцсийн дүнд дарангуйлагч тодрон гарах үндэс болжээ. Энэ явдалд Үндсэн хуулиар тогтоосон механизм ч бололцоо гаргаж өгсөн байна. Үүнийг дараахь байдлаар тоочин үзүүлж болох юм.

- 1) Гүйцэтгэх тэнхмийг байгуулах нь парламентын оролцоо, хяналтгүй явагддаг. Рейхс-ерөнхийлөгч Рейхстагийн өмнө тангараг өргөдөг¹⁶ боловч ард түмнээс шууд сонгогддог¹⁷, түүнээс хараат бус. Үүгээр АНУ-ын ерөнхийлөгчтэй төстэй. Гэхдээ АНУ-ын ерөнхийлөгчтэй адил засгийн газраа өөрөө толгойлдоггүй. Рейхс-ерөнхийлөгч бол төрийн тэргүүн юм¹⁸, харин засгийн газрыг түүнээс томилогдсон Рейхсланцлер тэргүүднэ.¹⁹ Энэ нь өнөөгийн ОХУ-ын системтэй төстэй. Гэвч ОХУ-ын Засгийн газрын тэргүүнийг Ерөнхийлөгчийн санал болгосноор Дум томилдог, энэ нь Дум засгийн газартай хариуцлага тооцох механизм бий болгож байна. Гэтэл Ваймарын Иргэн улсад ийм механизм үгүй байсан юм.

¹⁶ Ваймарын Үндсэн хууль 42 дугаар зүйл

¹⁷ Ваймарын Үндсэн хууль 41 дүгээр зүйл

¹⁸ Ваймарын Үндсэн хууль 45 дугаар зүйл

¹⁹ Ваймарын Үндсэн хууль 53, 55 дугаар зүйл

Гүйцэтгэх эрх мэдэл парламентын хяналтаас гадуур байсан нь Рейхс-ерөнхийлөгчийг ашиглан улс төрийн хүчин төрийн эрхэд гарах замыг засчээ. Энд Ерөнхийлөгч асан Гинденбургийн сул тал хүчтэй нөлөөлсөн гэж үздэг.

2) Ихэнх ерөнхийлөгчийн засаглал хоёр тэнхимтэй парламент бүхий байдаг бол Ваймарын Иргэн улс өмнө өгүүлснээр ганц тэнхимтэй парламенттай байлаа.

- a. Хоёр тэнхимтэй парламент нь Британы түүхэнд тохиолдсон шиг Эзэн хаан парламентыг хувааж, дунд нь улс төрийн ашиг хонжоо унагах аюултай. Гэвч нөгөө талаар гүйцэтгэх засаглалын тэргүүн нэгэн зэрэг хоёр тэнхимтэй санал нийлэх тохиолдол бараг байхгүй юм. Иймээс гүйцэтгэх засаглалын бодлого ямагт хэн нэгнийх нь хяналтад байдаг.
- b. Хэрэв парламентын хоёр тэнхим хоёул Ерөнхийлөгчийн эсрэг санал нийлвэл, түүнийг албан тушаалдаа огтоос тохирохгүй нэгэн хэмээн үзэж, импичмент хийх үндэс болно.
- c. Зөвхөн онолын хувьд л парламентын хоёр тэнхим, Ерөнхийлөгч гурав улс төрийн тодорхой нэгэн эмзэг асуудлаар гурвуул санал нэгтэй байх бололцоо байж болох бөгөөд энэ тохиолдолд тэр бодлого хамгийн төгс төгөлдөр бодлого болж таарна.
- d. Улс төрийн талаасаа төрийн эрхийг барих энэ гурван институцийг нэг нам дангаараа гурван сонгуульд ялж барих магадлал онолын хувьд байж болох авч амьдрал огт бололцоогүй зүйл мөн. Иймээс төрийн эрх ганц намын гарт төвлөрөхөөс сэргийлэх найдвартай механизм болдог байна.

Үүнд л тэнцэл хяналын зарчмын гол баримтлал оршино. Ганц парламенттай, гүйцэтгэх эрх мэдэл нь хууль тогтоох эрх мэдэлтэйгээ ерөөсөө огтлолцдоггүй Ваймарын энэ байгуулал нь тодорхой улс төрийн хүчин гагцхүү ерөнхийлөгчид лобби хийх замаар хяналтгүйгээр засгийн эрхэнд гарах бололцоог нээж өгсөн юм.

- 3) Нөгөө талаас порпорциональ системийн сул тал үүнд нөлөөлсөн байдаг. Ерөнхийлөгчийн засаглалтай ихэнх орны парламент мажоритар системээр явагддаг.
 - a. Мажоритар систем нь “сайн хүмүүс”-ийг парламентад цуглуулж мэргэн шийдвэр гаргахад чиглэдэг. Энэ нь хүчтэй боловсон хүчин бүхий том намуудад ашигтай ба жижиг намуудад ашиггүй байдаг. Намууд хүчтэй хүмүүсээр дамжуулан хуульд бодлогоо тусгуулдаг. Энэ нь ихэвчлэн Ерөнхийлөгч хэмээх хүчирхэг институцийг сөрөх боломжийг бий болгоно.
 - b. Харин порпорциональ систем нь нийгмийн олон бүлгийн ашиг сонирхлын тэнцвэрийг хангахад чиглэнэ. Парламентад хүчтэй сонирхол олон хувийн санал авч илэрхийлэгдэх бөгөөд ингэснээр хуульд биелэлээ олох бололцоо нээдэг. Эид хувь хүний хүчин зүйлээс илүү төлөөлж буй ашиг сонирхол нь чухал байдаг.
 - c. Ваймарын Иргэн улсын дотоодод бий болсон улс төрийн тогтворгүй байдлын толь нь Рейхстаг болж, тэнд нацист намын мандат хүчирхэг байлаа. Парламентын хяналтаас гадуур томилогдсон Рейхсканцлер энэ байдлыг ашиглан парламентыг шахаанд оруулах чадалтай болжээ.
- 4) Алдарт 48 дугаар зүйлийн ач холбогдол энд бас оршино. Энэ бол онц байдал тулгарсан үед зэвсэгт хүчин хөдөлгөх эрхийг Ерөнхийлөгчийн гарт

төвлөрүүлсэн явдал мөн. Үүнээс дутуугүй ач холбогдолтой заалт бол Үндсэн хуулийн 25 дугаар зүйл бөгөөд Рейхс-ерөнхийлөгчид парламентыг нэг удаа тараах эрх олгосон байдаг. Түүхэн тохиолоор Гинденбургийг нас бармагц эдгээр онцгой эрх 51 дүгээр зүйлийн дагуу Рейхс-ерөнхийлөгчийг орлох Рейхсканцлер Гитлерт шилжжээ.

Бид өнөөдөр Адольф Гитлер тэргүүтэй нацистууд ардчилсан сонгуулиар, хууль ёсны дагуу засгийн эрхэд гарсныг харж байна. Харамсалтай нь гүйцэтгэх эрх мэдэлд гарсан улс төрийн хүчнийг парламентаас хянах, бололцоогүй байжээ. Энэ нь төрийн эрхэд гарсан улс төрийн хүчнүүдийн хүчний тэнцвэрт Үндсэн хуулийн эрх мэдэл хуваарьлалт нь тэнцвэргүй, уялдаагүй байдал үүсгэсэн харагдаж байна.

Германы Холбоот Иргэн Улс * * * * *

Дэлхийн хоёрдугаар дайн дуусмагц, эзлэгдсэн Германы нутаг дэвсгэрийг дөрвөн хэсэгт хувааж Холбоотнууд түр захиргаа байгуулсан бөгөөд хожим Британ, АНУ, Францын асрамжийн хэсэг нийлж Германы Холбоот Иргэн Улсыг байгуулсан билээ. Үүний хариу болгож БНАГУ-ыг байгуулсан нь хүйтэн дайны яруу тод эхлэл байлаа.

Германы үндсэн хуульт ёсны түүхийг өгүүлэхэд БНАГУ-ын үндсэн хуулийн тухай ярихгүй байж болохгүй юм. БНАГУ-ын үндсэн хууль нь өөрийн өвөрмөц онцлог бүхий социалист төрийн байгууллын нийтлэг жишгийг тогтоосон байдаг. Энэ нь Зөвлөлтийн коммунист хүчирхийллийн дарамтад асан улс төрийн нөхцөл байдлыг илтгэдэг. Иймээс тухайн үндсэн хуулийн онцлогийн талаар социалист эрх зүйн харьцуулалтын хүрээнд уг үндсэн хуулийн тухай ярина. Харин энэ өгүүллийн хүрээнд энэ асуудлыг түр хойш тавьж ямар улс төрийн хүчин зүйл Германы Холбоот Иргэн Улсын Үндсэн хууль, түүгээр тогтоосон

төрийн байгуулалтад нөлөөлөв гэдгийг шүүмжлэн үзэхийг зорилоо.

Дэлхийн хоёрдугаар дайнд ялагдсан Германы улс төрийн гадаад орчин нэгдүгээр дайнд ялагдсан Германыхаас олон зүйлээрээ онцлог байлаа. Нэгдүгээр дайны дараа Герман улс империалист гүрнүүдийн санаа нэгтэй дарамтад байсан байсан. Харин хоёрдугаар дайныг шууд залгаад хүйтэн дайн эхэлсэн тул үзэл суртал, геополитикийн үүднээс дайсагнагч хоёр этгээдийн аль аль нь Германыг алдах сонирхолгүй байсан юм.

Дайны дараа нийгмийн хамгааллын бодлогыг тууштай барьснаар боловсон хүчний бэлэн нөөцийг урамшуулан дайчлах боломжтой болж, богино хугацаанд эдийн засгаа сэргээн босгож чадсан билээ. Энэ бодлогыг хожим “нийгмийн баримжаатай зах зээлийн эдийн засаг”^{****} хэмээн нэрийдэх болжээ²⁰.

Энэ бодлогын зорилтыг төрийн байгууллын хүрээнд онолын дараахь баримтлалаар дэмжин баталгаажуулжээ.

- Ардчилал
- Эрхзүйт төр
- Социаль төр
- Холбооны улс
- Иргэн улсын байгуулал зэргийг тэргүүлэх үндсэн таван үзэл баримтлал хэмээн үзсэн байдаг.²¹

Эдгээр баримтлалыг эш болгон Германы Холбоот Иргэн Улсын Үндсэн хуулийг Парламентын зөвлөлөөс 1949 оны 5 дугаар сарын 23-ны өдөр батлан тунхагласан юм.

²⁰ *Gernot Gutmann* “The Intellectual Basis and Historical Development of Social Market Economy”. *Social Market Economy; An Economic System for Developing Countries*. *Winfried Jung* (ed) Internationales Institut Konrad Adenauer Stiftung. Sankt Augustin 1991, pp 13-33

²¹ *Alfred Katz* “Staatsrecht” Heidelberg 1991, S.132

Холбооны Германы энэ Үндсэн хууль нь өмнөх үндсэн хуулиудаас дараахь үндсэн ялгаатай байна.

◀ Анх удаа Парламентын засаглалыг тунхаглан зарласан. 1871 оны Үндсэн хуулиар Эзэн хаант төрийн байгуулал, 1919 онд Ерөнхийлөгчийн иргэн улсын байгууллыг тогтоосон бол энэ удаа Парламентын засаглалыг сонгон тогтоосон байна.

◀ Парламентын засаглалыг авахдаа сонгодог хэмээн тооцогддог Британы парламентын системийг авалгүй тэнцэл хяналын өөрийн онцлогтой системийг үүсгэжээ.

Германы Холбоот Иргэн Улсын Үндсэн хуулиар тогтоосон төрийн байгуулал нь дээр өгүүлсэн зарчмыг удирдлага болгосон, өвөрмөц онцлог бүхий бүтэцтэй юм.

Парламентын засаглалын хүрээнд төрийн эрх мэдлийг хуваарилах зарчмыг авч хэрэглэсэн явдал нь өмнө дурдсанаар Британы парламентын засаглалаас онцлогтой юм. Боннын парламентат ёс хэмээн нэршсэн байгууллын энэ системийн онцлогийг дараахь зүйлээр тоймлон өгүүлсэн байна. Үүнд:

- Ард түмний шууд оролцоог хязгаарлах
- Ард түмнээс шууд сонгогдох төрийн ганц байгууллага нь Парламент байх
- Засгийн газрыг байгуулах журам
- Канцлерын байр суурийг бэхжүүлэх
- Гүйцэтгэх тэнхимийг татан буулгах “конструктив” зарчим
- Парламентыг тараах болзлыг хатуу зааж, хязгаарласан
- Засаглал хоорондын харилцаа, хяналыг тодорхой тогтоосон
- Холбооны Ерөнхийлөгчийн эрх хэмжээг яс тогтоосон
- Намуудын эрх үүргийн системийг тодорхой заасан зэргийг тоочин үздэг байна²².

²² Alfred Katz “Staatsrecht” Heidelberg 1991, S.157-158

Төрийн байгууллын системийг нь авч үзвэл дараахь болно.

Хууль тогтоох эрх мэдлийг парламент хэрэгжүүлнэ. Парламент нь хоёр тэнхимтэй. Бундестаг буюу их тэнхим^{****} нь ард түмнээс дөрвөн жилийн хугацаатай шууд сонгогдох бөгөөд хуулийг эцэслэн батлах эрхтэй.²³ Бундестаг бол төлөөллийн гол байгуулга бөгөөд түүнийг бэхжүүлснээр ардчилсан тогтолцоо хамт бэхжих юм. Холбооны Ерөнхийлөгчийн санал болгосноор Холбооны Канцлерийг сонгоно.

Бундесрат буюу парламентын бага тэнхим^{*****} нь аливаа дээд тэнхимийн адил муж улсын сонирхлыг илэрхийлнэ. Гэхдээ энэ тэнхимийн үүрэг нь олон улсад түгсэн Сенат хэмээх уламжлалт институцээс ялгаатай. Сенат нь муж улсаас сонгогдон, хуулийн төслийг батлах зэрэг эрх хэмжээтэй байдаг. Гэтэл Бундестагийн гишүүд сонгогддоггүй, томилогддог, хуулийн төслийг шууд батлах эрхгүй. Бундесрат хууль санаачлан, Бундестагийн шийдвэрт хориг тавих эрх эдэлнэ²⁴.

Холбооны Ерөнхийлөгч нь Ваймарын Иргэн улсын Рейхс-ерөнхийлөгч шиг ард түмнээс шууд сонгогдохгүй харин Холбооны чуулган хэмээх институциэс сонгогдоно.²⁵ Холбооны чуулган нь Бундестагийн нийт гишүүд, түүнтэй тэнцүү тооны муж улсын төлөөллийн гишүүдээс бүрдсэн онцгой байгууллага агаад гагцхүү Холбооны Ерөнхийлөгчийг сонгох эрх хэмжээтэй. Чингэснээр Холбооны Ерөнхийлөгч нь хүн амын болон муж улсын аль алинийх нь ашиг сонирхолын нэгдмэл илэрхийлэл болох мөртөө Бундестаг, Бундесратаас аль алинаас нь хараат бус институц болно. Үүний гол ач холбогдол нь Бундестагаас Засгийн газартай харьцах харилцаанд тод илэрдэг.

²³ Германы Холбоот Иргэн Улсын Үндсэн Хууль 38-54 дүгээр зүйлийг үзнэ үү.

²⁴ *Alfred Katz "Staatsrecht" Heidelberg 1991, S.177*, мөн Германы Холбоот Иргэн Улсын Үндсэн Хууль 50-53 дугаар зүйлийг үзнэ үү.

²⁵ Германы Холбоот Иргэн Улсын Үндсэн Хууль 54 дгээр зүйл

Холбооны Ерөнхийлөгчийн санал болгосноор Холбооны Канцлерийг Бундестагаас сонгох бөгөөд Засгийн газрын гишүүдийг Ерөнхийлөгч томилно²⁶.

Эдгээр тогтолцоог Ваймарын Иргэн улсын байгуулалтай харьцуулан үзвэл дараахь хэдэн зүйл сэтгэгдэл төрж байна.

- Ваймарын Үндсэн хуулиар Рейхс-ерөнхийлөгч ард түмнээс шууд сонгогдохын хамт мөнхүү Рейхстагийг тараах дархан эрх эдэлдэг байсныг зарчмын хувьд өөрчлөн, Ерөнхийлөгчийг парламентын оролцоотой сонгох хувилбарыг хуульчилжээ. Холбооны Ерөнхийлөгч Бундестагийг тараах эрхтэйгээрээ Рейхс-ерөнхийлөгчтэй ижил боловч тийнхүү тараах нөхцөл журмыг Үндсэн хуульд өөрт нь зааж өгсөн байдгаараа Ваймарын Үндсэн хуулиас ялгаатай байна.
- Ерөнхийлөгчийг ийнхүү сонгохын хамт Холбооны Канцлерийг мөн л Бундестагаас сонгодог болсон нь гүйцэтгэх эрх мэдэл парламентын хяналтын гадна байсан Ваймарын Үндсэн хуулийн алдаанаас сургамж авсан хэрэг болтой (Ваймарын Иргэн Улс хэсгийг үзнэ үү).
- Дээрх хоёроос ургуулан харвал парламентын хяналтаас гадуур Ерөнхийлөгчийг ашиглан улс төрийн явцуу бүлэг төрийн эрхэд гарах урьдын бололцоог бүрэн хаасан байна.

Ийнхүү урьдах Үндсэн хуулийн механизмын доголдолтой талыг засахын хамт үүнээс урган гарах зохицуулалтын механизмыг Засаглал хуваах онолын үндсэн дээр шинээр боловсруулсан байна.

²⁶ Германы Холбоот Иргэн Улсын Үндсэн Хууль 63, 64 дүгээр зүйл

Хэрэв гүйцэтгэх эрх мэдэл хууль тогтоох байгууллагаас шууд сонгогдож байгаа бол түүний бие даасан байдлыг хэрхэн хангах вэ гэсэн асуулт зайлшгүй гарна. Парламентын засаглалтай үед энэ асуудлыг шийдэх нь хамгийн чухал ач холбогдолтой юм.

Үүнийг дараахь байдлаар шийдсэн нь сонирхол нэн татаж байгаа юм.

- Ерөнхийлөгчийн институцийн гол үүргийн нэг нь хууль тогтоох байгууллагын улс төрийн сонирхлыг Засгийн газар уруу оруулалгүй хааж байх үндсэн механизм болоход оршино. Канцлерийг нэр дэвшүүлэх үүрэг түүнд оногдож байгаа нь ийм учиртай.

- Канцлерт буюу Засгийн газарт итгэл үзүүлэх тухай асуудлыг хэлэлцэхэд “конструктив” зарчмыг оруулж өгсөн байна. Үндсэн хуулийн 67 дугаар зүйлийн дагуу хэрэв Канцлерт итгэл үзүүлэх эсэх тухай асуудлыг хэлцвэл эхлээд заавал канцлер огцорсон үед шууд батлагдах залгамжлагчийг тодруулан санал хурааж, олонхийн санал авсан хүний нэрийг Ерөнхийлөгчид өргөсний дараа асуудлыг хэлцэнэ. Хэрэв Канцлерт итгэл үзүүлэхгүй бол Ерөнхийлөгч өргөн дэвшүүлсэн хүний нэрийг шууд батламжилна. Тийн санал болгоод сонгох асуудлыг дөчин найман цагийн дотор шийдэх учиртай. Эл механизм Гүйцэтгэх эрх мэдлийг улс төрийн аливаа сонирхлоос харьцангуй бие даасан байх бололцоог олгож байна.

- Шинэ Канцлер сонгох буюу итгэл үзүүлэх асуудлыг шийдэж чадалгүй хугацаа алдсан явдал нь Ерөнхийлөгчид Бундестагийг тараах хууль зүйн үндэслэлийг олгоно.²⁷ Иймээс Гүйцэтгэх эрх мэдлийн институцийг сонгох, солих бүх асуудал Бундестагт улс төрийн институцийн хувьд эрсдэл бий болгодог. Энэ нь “шүүмжилж болно, харин огцруулах аюулгай” нөхцлийг үүсгэх агаад Гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын бие даасан байдлыг хангахад тустай байдаг.

²⁷ Германы Холбоот Иргэн Улсын Үндсэн Хууль 63, 68 дугаар зүйл; Л.Өлзийсайхан “Парламент” Улаанбаатар 2001, хуудас 93.

Энэ механизм нь Германы Холбоот Иргэн Улсын парламентын засаглалын загварыг түүний сонгодог хэлбэр хэмээн тооцогдож асан Британы Вестминистерийн хэмээх засаглалын системээс гол ялгаруулж буй онцлог нь мөн.

Дүгнэлт

Дээр өгүүлсэн бүхнийг сийрүүлэн дараахь дүгнэлтийг хийж болох юм.

- Германы төрийн байгууллын хөгжил нь түүхэн сонирхолтой зам мөрийг туулан ирсэн байна. Гурван үндсэн хууль гурвуул өөр өөр төрийн байгууллын хэлбэрийг бататган тунхаглажээ.

◀ 1871-1918 оны Үндсэн хууль нь Эзэн хаант засаглалыг

◀ 1919-1933 оны Үндсэн хуулиар Ерөнхийлөгчийн засаглалыг

◀ 1949 оны Үндсэн хуулиар Парламентын засаглалыг тус тус сонгон байгуулжээ.

Германы үндсэн хуулийн байгууллын хөгжлийг авч үзэхийг зорьвол энэ гурван байгуулал дахь нийтлэг болон ялгаатай шинжийг онцлон судлах шаардлагатай юм.

- Ийнхүү гурван зүйл Үндсэн хууль, түүнд бататгасан нийгмийн байгуулал нь тухайн үеийн нийгмийн улс төрийн зорилтын тусгал болон батлагдаж байгаа тал нийтлэг ажиглагдаж байна. Тухайлбал,
 - Кайзерын үндсэн хууль, түүгээр тогтоосон төрийн байгууллын гол зорилго бол тулгар нэгдсэн олон муж улсын ашиг сонирхолыг тэнцүүлж, үндэсний нэгдлийг хангах, холбооны засгийн газрыг бэхжүүлэхэд чиглэж байв.
 - Ваймарын үндсэн хууль, түүгээр тогтоосон төрийн байгууллын гол зорилго бол олон герман овог аймгийн нэгдлийг нэгэнт хангасан тул харин дотоодод ардчиллыг хөгжүүлэн нийгмийн анги бүлгийн ашиг сонирхлыг

тэнцүүлэн бататгахад чиглэсэн байв.

- 1949 оны үндсэн хууль, түүгээр тогтоосон төрийн байгууллын гол зорилго бол урьдын алдаа сургамжийг харгалзан ардчиллыг цаашид бэхжүүлэн эрх зүйт, социаль, төрийн зарчим дээр холбоот иргэн улсын байгууллыг бататгах замаар иргэний нийгмийг хөгжүүлэхэд чиглэжээ.
 - Кайзерын төр улс төрийн зорилгоо биелүүлэхийн тулд олон муж улсын ашиг сонирхлын тэнцвэрийг хангахад гол анхаарлаа хандуулж байлаа. Иймээс эрх мэдлийг муж улсын ашиг сонирхлыг илэрхийлсэн Бундесрат ба холбооны засгийн газрыг төлөөлсөн Эзэн хаан, түүний канцлер хоёрын харьцаанд хуваарилсан байна.
 - Ваймарын төр улс төрийн зорилгоо биелүүлэхийн тулд нийгмийн анги бүлгийн хоорондын ашиг сонирхлыг тэнцвэржүүлэхэд гол анхаарлаа хандуулж, тэдгээрийн төлөөлөл болсон Рейхстаг болон Рейхс-ерөнхийлөгчийн хооронд эрх мэдлийн цөмийг хуваарилжээ. Харамсалтай нь хуваарилалт оновчгүй байсан тул завсраас ямар ч хяналтгүйгээр төрийн эрхэд гарах магадлал бий болсон байна.
 - Холбооны төрийн улс төрийн зорилгоо биелүүлэхийн тулд анги бүлгийн ашиг сонирхлын тэнцвэртэй илэрхийллийн сацуу хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн хоорондын харилцан бие даасан, тэнцвэртэй, хяналттай байх механизмыг бий болгоход голчлон анхаарчээ.
- Төрийн эрх мэдлийн хуваарилалт нь түүхэн цаг үед тавигдсан улс төрийн зорилтыг шийдвэрлэхэд чиглэгджээ. Энэ гурван зүйл Үндсэн хуулийн өмнө тавигдсан улс төрийн тус тусын зорилтыг шийдвэрлэх явдалд улс төрийн бодлогоос гадна юун түрүүнд төрийн эрх мэдэл хуваарилахдаа анхаарч ирсэн байна.
 - Сүүлийн 130 гаруй жил өөртөө таарах төрийн байгууллын хэлбэрийг эрэн бэдрэх мэт явсан түүхэн хөгжлийг үзвэл гурван үндсэн хуульд бататгасан төрийн институц, тэдгээрийн эрх үүргийн зааг ялгаа, харилцан хамаарал зэрэг нь улам бүр тодорч, боловсронгуй болсоор иржээ.

Тайлбар

* National feeling буюу Национальное сознание гэх үгийг ийн орчуулав. Тодорхой ард түмэн, үндэстний оюуны соёлын хөгжил, онцлог бүхий нийгэм, улс төр, эдийн засаг, ёс суртахуун, гоо зүй, гүн ухаан, шашны гэх мэт олон зүйл үзэл бодлын нийлбэр цогц мөн.

** Zollverein хэмээх нь гаалийн нэгдэл хэмээх утгатай үг болно. Энэ нэгдэл нь 1834 оноос умард Германы ванлиг хоорондын арилжаа худалдааг зохицуулж өгсөн юм. Үүний үр дүнд тун богино хугацаанд германы угсааны бүх улсад аж үйлдвэржих явц эрчимтэй өрнөжээ.

*** Kulturkampf хэмээх нь соёлын тэмцэл хэмээх үг болой. 1872 онд Герман улс Католик сүмийн тэргүүн Ромын Паптай харилцаагаа тасалсан нь Эзэнт Гүрний бүрэлдэхүүнд байсан Бавар тэргүүтэй өмнөд муж улсуудын дургүйцлийг хүргэсэн байна. Тэдгээрийн бухимдлыг сарниулахын тулд Соёлын тэмцэл хэмээх улс төрийн том кампанит ажил зохион явуулсан байна.

*** Ландтаг гэдэг нь үгчилбэл нутгийн хурал хэмээх үг бөгөөд герман угсааны жижиг улсуудад эрх барьдаг чуулганы хэлбэрийг ийн нэрлэж байв. Өдгөө муж улсын хурлыг ийн нэрлэмой.

**** Республика гэх үгийг ийнхүү орчуулав. Энэ ухагдахууныг иргэн улс хэмээн анх орчуулдаг байсан нь хааны засгийг сөргүүлж тавьсан утгаараа зүйтэй орчуулга байжээ. Цаашид дэлгэрүүлэн О.Машбат, Д.Мөнх-Очир “Бүгд найрамдах улс хийгээд Иргэн улс” Эрхзүй сэтгүүл 2001 оны No дугаарт үзнэ үү.

***** Өмнөх тайлбарыг үзнэ үү.

**** Soziale Marktwirtschaft хэмээх нь “нийгмийн байримжаа бүхий зах зээлийн эдийн засаг” хэмээх агуулгатай болно. Эдийн засгийн хөгжлийн онцгой загвар хэмээн үзэх хандлага нэлээд дэлгэрэнгүй үзэгддэг. Дэлхийн хоёрдугаар дайны дараах Германы эдийн засгийн гайхамшгийн нууцыг нийгмийн баримжаатай зах зээлийн эдийн засагт байна гэлцдэг. Энэ загварыг судлахад тэр үеийн Германы нийгэм эдийн засгийн байдлыг тухайлан үзэх шаардлагатай болно. Цаашид дэлгэрүүлэн Winfried Jung (ed) “Social Market Economy; An Economic System for Developing Countries” Internationales Institut Konrad Adenauer Stiftung. Academia Verlag Richarz. Sankt Augustin 1991 номыг үзнэ үү

***** Erste Kammer хэмээх үгийг махчилбал “нэгдүгээр тэнхим” орчуулж болох авч агуулгыг нь барьж “их тэнхим” хэмээв. Энэ үгийг Алфред Катцийн “Төрийн эрхзүй” хэмээх сурах бичигт түгээмэл хэрэглэсэн байх аж. Парламентын дээд доод тэнхим хэмээн уламжлалт байдлаар орчуулж болох авч нэгдүгээрт, германы судлаачид дээд доод хэмээн ярьдаггүй, хоёрдугаарт, тийнхүү ангилах нь тухайлан өдгөөгийн Германы төрийн байгуулалд төдийлөн зохистой бус байна. Тиймээс “их тэнхим”, “бага тэнхим” хэмээн орчуулахыг илүүд үзэв.

***** Zweite Kammer өмнөх Erste Kammer хэмээх тайлбарыг үзнэ үү.

НОМ ЗҮЙ

- Die Verfassung des Deutschen Reiches (Kaiser Reichsverfassung 1871-1918). Цаашид дэлгэрүүлэн Германы гүүхэн албан баримтын архивийн вебсайт:<http://www.documentArchiv.de/ksr/verfksr.html> -аас үзнэ үү.
- Die Verfassung des Deutschen Reiches (Weimarer Reichsverfassung 1919-1933.) Вурцбургийн их сургуулийн номын сангийн олон улсын үндсэн хуулийн сангийн вебсайт: <http://www.uni-wuerzburg.de/rechtsphilosophie/hdoc/wrv1919.html> -аас хайна уу.
- Grundgesetz für die Bundesrepublik Deutschland. (Verfassung 1949.05.23) 4.Auflage. Nomosverlagsgesellschaft. Baden-Baden. 1994
- Alfred Katz. "Staatsrecht: Grundkurs im öffentlichen Recht" C. F. Muller Juristischer Verlag. Heidelberg. 1991
- Vaughn F.Bishop, J William Meszaros. "Comparing Nations; The developed and the developing world". D.C.Heath and Company. Toronto. 1980
- Winfried Jung (ed) "Social Market Economy; An Economic System for Developing Countries" Internationales Institut Konrad Adenauer Stiftung. Academia Verlag Richarz. Sankt Augustin 1991
- Anatole G.Mazour, John M.Peoples and Theodore K. Rabb (ed) "People and Nations; A World History". Harcourt Brace Jovanovich Publisher 1988
- Л.Өлзийсайхан. "Парламент". Улаанбаатар 2001 он.